

## ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/41 дугаар захирамжийг үндэслэн дор дурдсан байршилд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахим хэлбэрээр /интернетээр/ зохион байгуулахаар зарлаж байна.

Дуудлага худалдааны хэлбэр: Цахим хэлбэрээр /Интернетээр/ Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу Шивээговь сумын 1 дүгээр багт, Ерөнхий боловсролын сургуулийн урд талд 0.09 га /900м<sup>2</sup>/ газрыг “Сургалтын төв”-ийн зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа явагдана.

1. Эзэмшүүлэх хугацаа: 15 жил /арван таван/
2. Анхны үнэ: 720.000 /Долоон зуун хорин мянган/ төгрөг  
Дэнчин: 72.000 /Далан хоёр мянга/ төгрөгийг 100220029002 дансанд тушааж баримтыг хавсаргана.
3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамжийг 100220300941 дансанд тушааж баримтыг хавсаргасан байх.
4. Гэрээний зүйл: Шивээговь сумын 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заасны дагуу ашиглахтай холбогдсон зураг төслийг газар эзэмших гэрээ байгуулснаас хойш 6 сарын дотор багтаан боловсруулж ирүүлнэ.
5. Цахим хуудас: Газрын цахим биржийн [www.mle.mn](http://www.mle.mn) хаягаар найдвартай сүлжээний доголдолгүй газраас нэвтэрч оролцоно.
6. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа: Дуудлага худалдаанд оролцогчдыг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 08 цаг 30 минутаас эхлэн 2020 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн 08 цаг 30 минут хүртэл зөвхөн ажлын өдрүүдэд, ажлын цагаар /08:30-17:30/ бүртгэж, баталгаажуулна.
7. Дуудлага худалдаа эхлэх: Газрын цахим биржийн [www.mle.mn](http://www.mle.mn) хаягаар 2019 оны 06 дүгээр сарын 12-ны өдрийн 09:00 цагаас эхлэнэ.
8. Дуудлага худалдаа явагдах хугацаа: 2020 оны 06 дүгээр сарын 12-ны өдрийн 09:00 цагаас эхлэн 15:00 цаг хүртэл тасралтгүй үргэлжилнэ.
9. Дуудлага худалдааны ялагчийг тодруулах журам: Дуудлага худалдаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогч ялагч болох бөгөөд ялагч нь дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ хугацаанд нь ирүүлж, дэнчин болон улсын тэмдэгтийн хураамжийг бүрэн төлсөн, өөрийн мэдээллээ үнэн зөв гаргасан, дуудлага худалдааны дэг журмыг зөрчөөгүй байна.
10. Газрын байршил, хил хязгаарын зураг схем:

### Газрын байршил, собилцол

315512.01	5108690.431
315542.01	5108690.431
315542.01	5108720.431
315512.01	5108720.431



11. Техникийн нөхцлүүд: Газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллага бүрэн хариуцна.
12. Дуудлага худалдаа явуулах газрын байршил, хил хязгаар, заагийг харуулсан зураг, схем, холбогдох зөвшөөрлийн хуудас болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг аймгийн ГХБХБГ-ын 108 тоот өрөө болон Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын 2 давхар 213 өрөөнд өгч байна.

Жич: Дуудлага худалдаанд оролцогч нь Газрын цахим биржийн [www.mle.mn](http://www.mle.mn) сайтын талаар болон Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2018 оны 07 сарын 09-ний өдрийн А/121 дугаар тушаал зэрэгтэй урьдчилан сайтар танилцах шаардлагатай.

